



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/117

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.4.2 дах зүйлийн 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Боржигон овогт Болдбаатарын Маанийдайрий нь (ЗН91011500) Сүмбэр сумын Ганзам багийн Замчдын гудамж 107в тоотод байрлах Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 593м² газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул Боржигон овогт Энхбаатарын Ариунтунгалагт (НЮ88053105) Сүмбэр сумын Ганзам багийн Замчдын гудамж 107в тоотод байрлах 593м² газрыг Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмших эрхийг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (Э.Ариунтунгалаг)-т үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Э.Ариунтунгалагт эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/82 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Г.БАТСУУРЬ

421400275



Аймгийн Засаг даргын 2024 оны
03. сарын 26-ны өдрийн 4/112 дугаар
захирамжийн хавсралт



Боржигон овогт Энхбаатарын Ариунтунгалагийн эзэмшилд
шилжүүлж байгаа газрын байршлын зураг

Сумын нэр	Багийн дугаар	Газрын хэмжээ /м ² /	Эзэмших хугацаа /жил/	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
Сүмбэр	1	593	5	Гэр бүлийн хэрэгцээ	Замчдын гудамж 107в тоот

